

МОНГОЛ ҮГИЙН ҮНДСЭН УТГА БАЛАРХАЙШИХ ҮЗЭГДЭЛ

Ж.Сэржээ *

Орчин цагийн монгол хэлний томоохон тайлбар толиудыг ажиглан үзвэл монгол хэлний ойролцоо утга бүхий, хоёр үгээс бүрдсэн хоршоо үгийн бүтцэд орж буй үг тус бүрийн үндсэн утга бүдгэрэн балархайших үзэгдэл нилээд өргөн ажиглагдах болов. Жишээлбэл **төрөл садан, садан төрөл** хэмээн олонтоо ярьж бичиж байгаа боловч төрөл гэдэг үг нь ямар утгатай, садан гэдэг үг нь ямар утгатай, хоорондоо утгын ямар ялгаатайг нарийн ойлгон тайлбарлаж чадахгүй болсноос зарим тайлбар тольд төрөл гэдэг үгийг нь садан, садан гэдэг үгийг нь төрөл хэмээн нэгийг нөгөөгөөр нь тайлбарласнаас хоёр үг хоёулаа тайлбаргүй болоход хүрч байна. Ийнхүү тодорхой тайлбаргүйг нь далимдуулан дээрх хоёр үгийг хэтэрхий мушгин тайлбарласан тохиолдол ч гарах болов. Жишээлбэл Боловсрол, соёл, Шинжлэх ухааны яамнаас /хуучин нэрээр/ айл өрх бүрт тараах зорилгоор 2010 онд эрхлэн хэвлүүлсэн “Монгол улсын иргэн үгийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар” хэмээх 14,58 хэвлэлийн хуудас бүхий том номдоо МУ-ын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Биологийн шинжлэх ухааны доктор Ж.Батсуурь, доктор Э.Энхмаа нар **төрөл садан** гэдэг хоршоо үгийг “эцгийн талын төрлийн холбоог илэрхийлсэн ерөнхий нэршил /65-р тал/, **садан төрөл** гэдгийг нь эхийн талын төрлийн холбоог илэрхийлсэн ерөнхий нэршил”/67-р тал/ гэж тайлбарлан бичсэнийгуншаад манай эрдэмтдийн эх хэлний мэдлэг арай ч ийм дор орчихоогүй байлгүй гэж цайруулан бодсоноо нуух юун. Монголчууд эцгийн талынхаа ах дүүсийг авга, эхийн талынхаа ах дүүсийг нагац хэмээн хэдэн мянган жил нэрлэж ирсэн биш үү?Түүнээс гаднахир **буртаг** гэдэг хоршоо үгийн буртаг гэдгийг нь “бузар зүйл, бохир юм” гэж тайлбарлаад хир гэдгийг нь буртаг хэмээн тайлбарласан, өөрөөр хэлбэл хоёр үг дундаа ганц тайлбартай байгаа гэх мэтийн жишээ олон бий. Тухайлбал:*хөвч тайга, булаг шанд, зүлэг ширэг, тал хээр, хоол хүнс, хөлөг морь, цалин хөлс, чадал тэнхээ, алах талах,дайн дажин, удам угсаа, наргих цэнгэх, гуу жалга, жалга судаг, ухаа зоо, хөндий хоолой, аараг бөөрөг, эрдэм боловсрол, амар амгалан, яр шарх, хөөх туух, гоёх гоодох, үр дүн, бие бялдар, хувь нэмэр,дуу хоолой, ан гөрөө, ам бүл, айл өрх, хоршоо дэлгүүр, согтуу хөлчүү,хужир мараа, манан будан, сан хөмрөг, өвчин эмгэг, эм тан, ихэс дээдэс, нүүр царай, хөх дэлэн,гуя хас,гал голомт, гэдэс гүзээгэх* мэтийн олон арван үгийг төвөггүй дурдан тоочиж болно. Өөрөөр хэлбэл энэ үзэгдэл цөөн хэдэн үгийн хүрээнд ховор тохиолдож байгаа биш,өнөөгийн монгол хэлэнд олонтоо тохиолдож байгаатүгээмэл үзэгдэл болжээ. Эдгээр хоршоо

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Монгол хэлний тэнхим

үгийн утга нь түүний доторх үг тус бүрийнх нь утгатай ойролцоо байгаа бөгөөд одоохондооулс **төр, зах зээл, эдийн засаг, санхүү /хүү сан= сан хүү/ эрх чөлөө, ард түмэн, аж ахуй, хүн ам, үнэ цэнэ**гэх мэтийн хоршоо үгс шиг бүрмөсөн нэг утга илэрхийлдэг нийлмэл үгболчихоогүй, бас **хана хэрэм, хашаа хороо, үс ноос, аяга шаазан, түлээ түлш, ой мод, говь цөл, хэл ам, ах дүү, айл саахалт, хэрүүл тэмцэл, дов толгой, дэнж дэвсэг, өвс ногоо, мөнгө төгрөг**гэх мэтийн хоршоо үг шиг бүрдүүлж буй гишүүн тус бүрийнх нь утга тодорхой байж чадахгүйгээрээ онцлог юм.

Энэ үзэгдэл өнөөгийн монгол хэлэнд зөвхөн хоршоо үгийн хүрээнд ажиглагдаж байгаа биш юм. Тухайлбал, нэрлэн зааж байгаа цаад юм үзэгдэл нь хуучран алга болоогүй хэвээр байгаа боловч түүнийг нэрлэсэн үгийн бодит, бие даасан утга нь орчин цагийн монгол хэлэнд бүдгэрч, хүн бүр сайн мэдэхгүй, толь бичгүүдэд ч оновчтой тайлбаргүй болж байгаа**сарьдаг, царам, овог, ураг** зэрэг хэдэн арван үг бас бий

Энэ үзэгдлийн талаар миний бие хоёр жилийн өмнө “Монгол хэлний төрөл садан, удам угсааг заадаг зарим үгийн утгын тухай” гэсэн өгүүлэл бичиж байсан билээ. /Сэржээ Ж. 2012 он/ Харин энэ удаа уул ус, ой тайга, газрын гадаргын шинж байдлыг нэрлэн заасан зарим цөөн үгийн утгын тухай асуудлыг **2008 онд Улаанбаатар хотноо хэвлэгдсэн 5 боть Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь /Цаашид Дэлгэрэнгүй тайлбар толь гэх/, 1966 онд Улаанбаатарт хэвлэгдсэн Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь /цаашид Товч тайлбар толь гэх, 1999 онд БНХАУ-д хэвлэгдсэн Ц.Норжин нарын Монгол хэлний толь /Цаашид Монгол хэлний толь гэх/, 2001 онд Москва хотод хэвлэгдсэн 4 боть Большой академический монгольско-русский словарь/ Цаашид Монгол-орос их толь гэх/зэрэг Монгол, Оросын холбооны улс, БНХАУ-ын шинжлэх ухааны академийн хүрээлэн байгууллагууд олон арван жилийн турш судлан боловсруулж хэвлүүлсэн, орчин цагийн монгол хэлний хамгийн том, олон үгийг багтаасан тайлбар толь болон хоёр хэлний толь бичгүүдэд тулгуурлан товчөгүүлэхийг зорилоо. Өөрөөр хэлбэл, эдгээр үгийн тухай асуудлыг хөндөхдөө монгол хэлний гол гол тайлбар толиудыг баримт болгон ашигласан юм. Учир нь, аливаа хэлний тайлбар толь тухайн хэлнийхээ үгийн санг багтаан, үгийн гол болон салаа утга, түүний хэрэглэгдэх хүрээ, хэл зүйн онцлог зэргийг тайлбарласан байх бөгөөд хэл шинжлэлийн бусад тольтой харьцуулахад олон нийтэд ихээхэн хүртээмжтэй байдгаараа онцлог юм.**

ХӨВЧ гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “уул нуруу зэргийн үргэлжилсэн өндөрлөг газар” хэмээн тайлбарласан бол **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Уул нуруу үргэлжилсэн өндөрлөг газар, мөн өндөрлөгт тогтсон ягц мод” хэмээн тайлбарлаад **эзэнгүй хөвч** /ойр тойронд нь хүн амьдардаггүй, алслагдсан ой мод, уул ус бүхий газар/, **ой хөвч** хоршоо /аглаг битүү ой мод/, **уул хөвч** хоршоо /хүний хөлөөс хол, өтгөн шигүү ой мод бүхий аглаг уул нуруу/, **хангай хөвч** хоршоо /өндөр уул нуруу, гол горхи, ой мод жигдэрсэн газар/, **хөвч царам** хоршоо /аглаг зэлүүд, өтгөн ой мод бүхий өндөрлөг сэрүүн газар/, **хөвч тайга** хоршоо /аглаг зэлүүд өтгөн ой мод, уул нуруу бүхий газар/ гэсэн холбоо үг болон хоршоо үгээр жишээ татсан байна. Ц.Норжин нарын **Монгол хэлний тольд**: “Уул нурууны үргэлжилсэн өндөрлөг газар” гээд **хөвч ой** /өвч бүрхсэн балар ой/ гэсэн тайлбарыг өгчээ. Тэгвэл **Монгол-орос их тольд** Хөвч гэдэг үгэнд горный массив, лес, тайга гэдэг үгсийг оноогоод **уул хөвч** /горный массив, лес/, **ой хөвч** /тайга/, **хангай хөвч** /горный лес, тайга/, **хөвч газар** /тайга/ гэх мэтийн холбоо үгсийг жишээ болгон авсан байна.

Эдгээр тайлбаруудыг ажиглан үзвэл “хөвч” гэдэг үгийг Монгол хэлний товч тайлбар толь болон дэлгэрэнгүй тайлбар толиуд хийгээд Монгол хэлний тольд “үргэлжилсэн уул нуруу бүхий өндөрлөг газар” хэмээн тайлбарласан бол Монгол-орос дэлгэрэнгүй их толь дээрх үгэнд *уулс, ой мод, тайга* гэсэн утга бүхий орос үгийг оноожээ. Бас Өвөр монголын Ардын хэвлэлийн хорооноос 1994 онд хэвлэсэн **Хорин наймт тайлбар тольд** “өндөр уул хянга залгалдсан уужим шил газрыг хөвч хэмээмүй” гэж тайлбарласан байна. Ийнхүү хөвч гэдэг үгийн үндсэн утгыг дээрх толиудад “үргэлжилсэн уул нуруу бүхий өндөрлөг газар” гэж нэгэн адил тайлбарласан боловч жишээ болгон авсан хоршоо, үг холбоо үгсээ “ой модтой уул”, “өтгөн их ой мод” хэмээн тайлбарласан нь зөрчилтэй болсон байна. Тухайлбал, **Дэлгэрэнгүй тайлбар тольд** хөвч тайга гэдэг хоршоо үгийг аглаг зэлүүд өтгөн ой мод, уул нуруу бүхий газар гэж тайлбарлажээ. Монголын их зохиолч Д.Нацагдорж “Миний нутаг” шүлэгтээ:

Хэнтий Хангай Соёны өндөр сайхан нуруунууд

Хойд зүгийн чимэг болсон ой хөвч уулнууд гэж ой мод гэсэн утгаар шүлэглэжээ.

ТАЙГА хэмээх үгийг **Товч тайлбар тольд**: “ой хөвч бүрхсэн өндөр аглаг уул нуруу” хэмээн тайлбарласан бол **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “хөндөгдөөгүй ой хөвч бүрхсэн өтгөн шигүү, өндөр аглаг уул нуруу” гэж тайлсан байна. Бас Ц.Норжин нарын **Монгол хэлний тольд**: “1. Балар ой, 2. Ой бүрхсэн өндөр уул” гэж тайлбарласан байна. Энд байгаа, өтгөн шигүү, өндөр аглаг уул нуруу гэдэг тайлбарыг хэрхэн ойлгох вэ? Түүнийг л тайга гэдэг гэнэ. Тэгвэл **Монгол-орос их тольд**: “1. дремучий лес, 2. Горный лес “ гэсэн нь манай тайлбар толиудыг бодвол тайга гэдэг үгийн утгыг илүү оновчтой, тодорхой гаргаж чадсан байна. **Өөрөөр хэлбэл, аглаг газарт орших балар битүү, өтгөн их ойг тайга гэдэг ажээ.**

Хөвч Тайга гэсэн хоёр үгийг өнөөгийн монгол хэлэнд утгын тодорхой ялгаагүйгээр, ихэвчлэн хоршоо үгийн хэлбэрээр хэрэглэж байгаагаас үүдэн уг хоёр үгийн үндсэн утга нь бүдгэрч толь бичгүүдэд ч тодорхой бус болсныг дээрх тайлбарууд нотолж байна. **Уг нь тайга гэдэг үг балар их ой модтой холбоотой бол хөвч гэдэг үг нь газартай /уул нуруу үргэлжилсэн өндөрлөг газар/ илүү холбоотой бололтой. Өөрөөр хэлбэл, аглаг газарт орших балар битүү, өтгөн их ойг тайга гэдэг бол, дээр нь тэр их ой мод ургасан үргэлжилсэн их уул бүхий газар нутгийг хөвч хэмээн энэ хоёр үгийн үндсэн утгыг ялган ойлгож болох юм.** Харин өнөөдөр энэхүү утгын ялгаа балархайшин бүдгэрч, хоёуланг нь **өтгөн их ой мод үргэлжилсэн уул нуруу** гэж ойлгодог болсон ажээ. Үүнийг хөвч гэдэг толгой үгээс үүссэн ой хөвч, уул хөвч, хангай хөвч, хөвч царам, хөвч тайга гэсэн хоршоо үгсийн тайлбар нотолж байна.

ЦАРАМ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Уулын хяр, хөндий, хоолой, хөвч мэтийн өндөр газарт жавар, сэрүүн хялбар тусах газар” хэмээн тайлбарлаад **таг царам** хоршоо /өндөр уулын оройн хүн амьтан хүрэхэд бэрх аглаг хэсэг/, **хөвч царам** хоршоо /аглаг зэлүүд, өтгөн ой мод бүхий өндөрлөг сэрүүн газар/, **хангай царам** хоршоо /ой мод, гол горхи, өвс ургамал жигдэрч уул нуруу хосолсон газар болон уул хоорондын хөндий хоолой газар/ гэсэн байна. Энэ тайлбарыг яаж ч уншаад царам гэдэг үг юуг нэрлээд байгааг ойлгоход бэрх юм. Тухайлбал “Уулын хяр гэдэг нь өндөр газар мөн боловч хөндий, хоолой нь өндөр газар мөн үү? Түүгээр ч үл барам хангай царам гэдэг хоршоо үгээ “... уул хоорондын хөндий хоолой газар” хэмээн тайлбарласан байна. Бас жавар, сэрүүн хялбар тусах гэж юу вэ? Гэрэл тусах, нар тусах гэвэл ойлгомжтой боловч жавар тусах, сэрүүн тусах гэж юу вэ? Энэ тайлбарыг хөөн үзвэл **Товч тайлбар толь**- оос эхтэй ажээ. Тэнд энэ үгийг “Хяр уулын завсрын хөндий хоолой газар ба

хөвч өндөр газар мэтийн жавар сэрүүн хялбар тусах газар” гэж тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл дэлгэрэнгүй тайлбар толийн зохиогчид 40 жилийн өмнө хэвлэгдсэн товч тайлбар толийн тайлбарыг шууд хуулбарлан авсан нь илт.Ц.Норжин нарын **Монгол хэлний тольд**: “Уулын завсрын салхи ихтэй хөндий хоолой газар буюу уулын жавар татах хяр, хөвч өндөр газар” гэж тайлбарлажээ. Царам хэмээх үг маань монгол хэлний Хорин нэгтийн тайлбар толь болон С.Шагжийн тайлбар толиудад байхгүй бөгөөд харин **Монгол-орос их тольд**: “Царам –горное плато; рытвины на склоне горы; высокогорная тундра; высокогорная местность с лишайниками и мхами” хэмээн орос хэлэнд утгыг нь тайлбарлан буулгасан нь манай тайлбар толь бичгүүдийн тайлбараас илүү оновчтой болсон гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, **уулын өндөрлөг сэрүүн газар бүрийг царам гэхгүй, харин өндөр уулын ар талын ойн бүсээс дээш орших бутлаг мод, хөвд, хаг өвс ургамалтай, асга хад бүхий хүнхэр хэлбэртэй тэгш бус газрыг царам хэмээн хэлдэг билээ.** Царам хэмээх энэ үгийг өнөөгийн монгол хэлэнд “ар цармын бялзуухай”, “сүүдэр цармын цэцэг” гэх мэтээр хэрэглэж байгаа жишээг ч олон хүн мэднэ.

САРЬДАГ гэдэг үгийг “1.Мөнх цаст уул, 2. Уулын ноён оргил, ян сарьдаг /өндөр уул нуруудын нүцгэн оргил/” хэмээн **Дэлгэрэнгүй тайлбар тольд** тайлбарлажээ. **Товч тайлбар тольд**: “мөнх цастай уул, уулын хөвчийн оргил өндөр” гэж тайлжээ. Харин Ц.Норжин нарын **Монгол хэлний тольд**: “1. Мөнх цаст уул, 2. Уул хөвчийн ноён оргил” гэж тайлжээ. Хорин нэгтийн тайлбар толь болон С.Шагжийн тайлбар толиудад энэ үг байхгүй бөгөөд **Монгол-орос их тольд**: “Сарьдаг- гора покрытая вечным снегом, голец” гэжээ. **Сарьдаг хэмээх үг маань мөнх цасаар бүрхэгдсэн, нүцгэн оргилтой өндөр уулыг нэрлэсэн үг бөгөөд дээр дурдсан тайлбаруудад байгаа Уулын ноён оргил, уулын хөвчийн оргил өндөргэсэн тайлбарууд шаардлагагүй, илүүц юм. Уулын ноён оргилыг биш, уулыг нь сарьдаг хэмээн нэрлэдэг /Хорьдол сарьдаг, Мөнх сарьдаг, Хийдийн сарьдаг гэх мэт/. Ян сарьдаг гэвэл өндөр уул нуруудын нүцгэн оргил биш, дан шовх хадан оргилтой уулыг хэлдэг.**

ЗҮЛЭГ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “1.Усархаг нам дор газар урт ургасан нарийн зөөлөн өвс, түүний нойтон чийгтэй хөрс газар. Зүлэгногоо /нуга хөндийн чийглэг газрын өвс ургамал/, зүлэг ширэг, ширэг зүлэг хоршоо. /нуга хөндий дагуух доворхог зүлэг/ гэж тайлбарласан байна. **Товч тайлбар тольд**: “үргэлжилсэн өвс үндэстэй, төрөлхийн нойтон чийгтэй” гэсэн ойлгомжгүй тайлбар хийгээд зүлэг суулгах /халцгай газар зүлэг дэвсч ургуулах/ гэсэн холбоо үгээр жишээ авчээ. **Монгол хэлний тольд**: “Зүлэг - зүлэг өвс ягц ургасан хөрс, бас ширэг гэдэг”, “Зүлэг ширэг – зүлэг сайтай газрын үндэс лүгээ барьцалдан нягтарсан хөрс” гэж хоёр толгой үг болгон тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, энэ тольд Зүлэг гэдэг үгийг зүлэг өвс ургадаг газрын хөрс гэж тайлбарласан бөгөөд бас түүнийг ширэг хэмээн нэрлэдэг гэжээ. **Монгол-орос их тольд**: “зеленый луг, мурава, лужайка; дёрн, газон; намаг зүлэг хорш. сырое место, болото, ногоон зүлэг зеленая трава, лужайка, зеленый газон; зүлэг суулгах сеять траву на газонах, покрывать дерном.” гэсэн үгсийг оноожээ.

ШИРЭГ гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “зүлэг” гэсэн бол **Дэлгэрэнгүй тайлбар тольд** “Зүлэг, шириг;” морь ширэг зулгаах /морь ногоон зүлэг идэх/, нойтон ширэг /чийгтэй зүлэг/, зүлэг ширэг хоршоо /ногоон өвс ногоо/ хэмээн зүлэг гэдэг үгээр нь тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл энэ хоёр тайлбар толь хоёулаа ширэг хэмээх үгийг зүлэг буюу “ногоон өвс, ногоо” гэсэн утгатай үг гэжээ. **Монгол хэлний тольд** энэ үг толгой үг болон ороогүй байна. **Монгол-орос их тольд**: “зеленый луг, лужайка, лужок,

дёрн; таримал ширэг газон, ширэг суулгах дёрновка, ширэгтэй хөрс дёрн; гэсэн үгийг оноосон байна.

Дээрх тайлбаруудаас үзвэл 1. Монгол хэлний дэлгэрэнгүй болон товч тайлбар толиудад зүлэг гэдэг үгийг өвс ногоо, түүний ургадаг хөрс гэж тайлсан байна. 2. Монгол хэлний тольд зүлэг гэдэг үгийг зүлэг өвс ургасан хөрс, бас ширэг гэдэг гэсэн бол Монгол-орос их тольд дээрх хоёр үгийг адилхан утгаар ойлгож, аль алинд нь “зеленый луг, мурава, лужайка; дёрн” гэдэг үгсийг оноожээ.

Зүлэг ширэг хэмээх хоёр үг нь хоёулаа голын хоёр талын хөвөө, жалга судаг зэрэг ус чийг ихтэй нам дор газар болон түүн дээр нягт ургасан, чийглэг жигдхэн ногоон өвс ургамалтай холбоотой боловч утгын тодорхой ялгаа бүхий бие даасан хоёр өөр үг юм. Тухайлбал, ширэг гэдэг нь хөрсний дээд хэсэг нь жигд өтгөн ургасан өвсний үндсээр хоорондоо ширэлдэн холбогдож хатууран биежсэн газрын хөрсийг нэрлэн заадаг үг бөгөөд түүн дээр жигдхэн ургасан нягт ногоон өвсийг нь зүлэг хэмээн нэрлэж байгаа хэрэг билээ. Ингэж хатууран биежсэн ширгийг хуулан авч өөр газар шилжүүлэн суулгаж болдог. Бас дээр үед байшингийн дээврийг хуулсан ширгээр бүрж бороо уснаас хамгаалдаг байсан бөгөөд түүнийг ширэглэх хэмээн нэрлэдэг. Ийм байшин дээвэр дээр нь өвс ургасан юм шиг харагддаг байсан билээ.

БУЛАГ гэдэг үгийг **Товч тайлбар тольд**: “газар дороос оргилон гарах ус” хэмээн тайлбарласан бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “Газар дороос ундрэн гарах ус. Булагбүрд /бяцхан ундарга устай хонхор/, булаг шанд /газраас ундрэн гарах ус/, горхи булаг /булаг шанд/, рашаан булаг /хүний биед эм болох эрдэс баялгийг агуулсан ус/ хэмээн тайлбарласан байна. **Монгол хэлний тольд** “газар дороос оргих ус” гэжээ. **Монгол-орос их тольд**: “родник, ключ, источник; булаг шанд хорш. источники, родники гэсэн үгийг оноожээ. Өөрөөр хэлбэл эдгээр толь бичгүүд булаг хэмээх үгийг нэгэн дуугаар “газраас ундрэн гарах ус” гэж тайлбарласнаар үл барам булаг шанд гэдэг хоршоо үгийг ч мөн ингэж тайлбарлажээ.

ШАНД гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд**: “бяцхан булаг; шандын ус /булгийн ус/, булаг шанд /газраас ундрэн гарах ус/, **Товч тайлбар тольд**: “бяцхан булаг ус” гэж тайлбарласан байна. Тэгвэл **Монгол хэлний тольд**: “1. гүехэн малтахад ус гардаг даацтай газар, 2. Даацтай газар малтаж гаргасан амны усавдаг бяцхан алам” хэмээн тайлсан байна. Даацтай газар гэдэг нь “Угийн балчиг шавартай, ус нэвчдэг газар” юм. **Монгол-орос их тольд**: “впадина, ложбина, где подпочвенная вода находится очень близко к поверхности земли, ключ, колодец в ложбине; булаг шанд хорш. ключ в ложбине, шанд ус хорш. колодец в ложбине; гэсэн үгийг оноожээ.

Бид булаг, шанд хэмээх хоёр үгийг ярианы болон бичгийн хэлэндээ олонтоо хэрэглэдэг боловч үг тус бүрийнх нь өөрийн үндсэн нарийн утгыг мэддэггүй. Тийм ч учраас **Товч тайлбар толь**-оос эхлээд монгол хэлний хамгийн сүүлд гарсан, **Дэлгэрэнгүй тайлбар толь** хүртэл Булаг гэдэг үгийг “газар дороос ундрэн гарах ус”, Шанд гэдэг үгийг “бяцхан булаг” гээд шандын ус /булгийн ус/ хэмээн энэ хоёр үгийг адил утгатай гэж үзээд шанд гэдэг үгийг булаг гэдэг үгээр нь тайлбарласан байна. Тэгвэл хоршоо үг болон олонтоо хэрэглэгддэг ч гэсэн энэ хоёр үг яг адилхан утгатай биш юм. Тухайлбал, булаг шанд хоёр хоёулаа газар дороос гардаг усыг нэрлэх боловч хангай газар шанд гэж нэрлэдэггүй, харин говьд шанд гэж хэлдэг. Тэгэхээр нэгдүгээрт, говьд шанд, хангайд булаг хэмээн нэрлэдэг ажээ. Хоёрдугаарт булаг гэдэг бол өөрөө газар дороос ундрэн гардаг ус бол, шанд гэдэг нь ус өөрөө аяндаа

нэвчин өнгөн хөрсөнд хүрч ирсэн газрыг малтаж гаргадаг ус юм. Говь газарт хулан туурайгаараа малтан гаргасан усыг Хулангийн шанд гэж нэрлэдэг билээ.

ЖАЛГА гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “цас борооны ус урсаж тогтсон хонхор газар, том жижиг гуу, жалгын ёроол /нарийхан хонхор газрын ёроол/, гүн жалга /гүнзгий хонхор гуу/, жалга сайр хоршоо /ус урсахаа больсон гуу/, жалга судаг хоршоо /чийглэг хөрстэй гуу/, ганга жалга хоршоо /эрэг ганга, гуу жалга/, гуу жалга хоршоо /огцом гүн жалга/, нуга жалга хоршоо /уул толгодын суга хөндий, гүн гуу/ гэж тайлбарласан бол **Товч тайлбар тольд:** “байгалиас тогтсон суваг гуу” гэжээ. **Монгол хэлний тольд:** “уул дов зэргийн хооронд аяндаа тогтсон өргөн гуу”, **Монгол-орос их тольд:** “1. Овраг, балка, узкий лог, ложбина, лощина; падь, ров, гуу жалга овраг” гэсэн үгсийг оноожээ. Өөрөөр хэлбэл монгол хэлний дээрх гурван том тайлбар толь гурвуулаа энэ үгийг “байгалиас тогтсон гуу” гэж тайлбарласан байна.

ГУУ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “суваг шуудуу, жалга ганга; гуу ганга хоршоо /жалга ганга/, гуу жалга хоршоо /ганга жалга/, **Товч тайлбар тольд:** “суваг, шуудуу, жалга”, **Монгол хэлний тольд:** “суваг мэт нарийн урт хонгил” гэж тус тус тайлбарласан бол **Монгол-орос их тольд:** “балка, ложбина, овраг; небольшая канава, ров; гуу ганга хоршоо пропасть, гуу жалга хоршоо балка, овраг, ложбина, падь, гуу суваг хорш. канава, ров, оросительный канал, арык;” гэсэн үгсийг оноожээ. Өөрөөр хэлбэл Монгол хэлний товч болон дэлгэрэнгүй тайлбар толиудад хоёуланд нь энэ үгийг “суваг, шуудуу, жалга”, гэж адилхан тайлбар өгчээ. Ингэснээр жалга гэдэг үгийг гуу, гуу гэдэг үгийг нь жалга гэсэн үгээр зөрүүлэн тайлбарласнаар энэ хоёр үг хоёулаа тайлбаргүй үлдсэн байна. Мөн Монгол-орос их тольд ч гэсэн “балка, ложбина, овраг, ров” гэсэн үгсийг аль алинд нь оноосноор дээрх хоёр үг бас л адилхан тайлбартай болжээ. **Монгол хэлний тольд** жалга гэдэг үгийг гуу гэж тайлбарласнаар хоёр үг маань дундаа ганц тайлбартай болжээ. Эдгээр тайлбараас юуг жалга, юуг гуу гэдэг нь үл мэдэгдэнэ. Түүгээр ч үл барам **Дэлгэрэнгүй тайлбар тольд** гуу ганга /жалга ганга/, гуу жалга /ганга жалга/ хэмээн нэг хоршоо үгийг нөгөө хоршоо үгээр нь тайлбарласныг математикийн тэгшитгэлийн аргаар аль алинд нь байгаа ижил үгийг хураавал гуу/жалга/, гуу /ганга/ болно. Өөрөөр хэлбэл гуу гэдэг үгэнд хоёр өөр тайлбар /гуу гэдэг маань жалга юм уу? ганга юм уу?/ өгсөн байна.

СУДАГ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “чийглэг хөрс бүхий нарийн зурвас газар; судаг газар /нарийн жалга маягийн чийглэг газар/, судгийн ногоо /судаг дагаж ургасан өвс ургамал/, ганга судаг хоршоо /цас борооны усанд эвдэрч тогтсон гуу болон чийгтэй хөрс бүхий зурвас газар/, гуу судаг хоршоо /гол усны элэгдлээс үүссэн суваг/, жалга судаг хоршоо /чийглэг хөрстэй гуу/ гэсэн бол **Товч тайлбар тольд** “нарийн жалга, суваг”, **Монгол хэлний тольд:** “бяцхан гуу жалга буй нахиу газар” гэж тус тус тайлбарласан байна. Тэгвэл **Монгол-орос их тольд:** “лог, ложбина, балка, промоина; нарийн судаг ложбина, үерийн судаг промоина от половодья” гэсэн үгсийг оноожээ.

ГАНГА гэдэг үгийг **Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд:** “1. Уул толгодын завсар, гуу жалга, цас борооны усанд идэгдэн гарсан суваг; ганга гуу хоршоо /гуу жалга/, ганга судаг хоршоо /цас борооны усанд эвдэрч тогтсон гуу болон чийгтэй хөрс бүхий зурвас газар/, эрэг ганга хоршоо /гуу жалга болон газарт өнгийж тогтсон ирмэг/, 2. Ихээхэн хэвгий газар **Товч тайлбар тольд:** “хоёр этгээдээс шахагдсан ихээхэн хавчил суваг” гэж тайлбарлажээ. **Монгол хэлний тольд:** “тал дээр буюу ялангуяа элсэн газарт олон байдаг ирмэг бүхий хонхор” гэсэн бол **Монгол-орос их тольд:** “высокий

берег, обрыв, яр; гуу ганга хорш. пропасть, эрэг ганга хорш. обрыв, круча, крутизна, крутояр, крутой берег; ганга жалга хорш. овраг; ганга сайр хорш. суходол; гэж орчуулжээ.

Жалга, Судаг, Ганга, Гуу гэсэн дөрвөн үг дөрвүүлээ газрын гадаргын атираа нугачааны доош суун хотгор болсон хэсгийг нэрлэдэг, утга нь хэдийгээр хоорондоо маш ойр, бие биетэйгээ харилцан холбогдож *жалга судаг, жалга ганга, ганга жалга, жалга гуу, гуу жалга, ганга гуу, гуу ганга* гэх мэтийн хоршоо үгсийг үүсгэдэг. Гэвч эдгээр үгийн хооронд утгын нарийн зааг ялгаа байх ёстой бөгөөд түүнийг олж тайлбарлах нь тайлбар толийн гол зорилго билээ. **Тухайлбал, Жалга,судаг хоёр бол ганга, гуу хоёроосоо хэмжээний хувьд том, ихэвчлэн хоёр уулын хооронд, эсвэл хоёр хамар, дэнж, дэвсэг зэрэг өндөрлөг газрын хооронд оршино. Өвөл хаврын улиралд цас ихээр хунгарлан тогтдог учир бусад газраас илүү их чийг авдаг. Нэгэнт чийг ихтэй болохоор өвс ногоо их ургах ба гантай жил ч гэсэн ногоон өнгөтэй харагддаг. Бас заримынх нь ёроол ус шалбааг бүхий дов сондуултай, бут мод, борог өвс ургасан ч байдаг. Судаг гэдэг үг ганга гэдэг үгтэй нийлж хоршоо үг үүсгэдэг боловч ганга, гуу гэдэг үгтэй нийлж хоршоо үг бараг үүсгэдэггүй. Энэ бол судаг гэдэг маань гуу, гангаас утгын хувьд нилээд хол, ганга гэдэг үгтэй утга нь ойр болохыг гэрчилнэ. Харин жалга гэдэг үг нөгөө гурван үгийнхээ алинтай ч хоршоо үг үүсгэдэг бол гуу гэдэг үг судаг гэдэг үгтэй нийлж хоршоо үг үүсгэхгүй. Энэ нь судаг, гуу гэсэн хоёр үгийн утга хоорондоо нилээд ялгаатайг харуулж байна. Тэгвэл ганга, гуу нь жалга судагтайгаа адил хотгор боловч хэмжээний хувьд бага, үерийн усанд эвдрэн эрэг гарсан, ёроол нь сайр чулуу, элс шороо бүхий газар юм. Жалга, судаг хоёр ч бас хоорондоо ялгаатай. Тухайлбал, жалга нь судгаасаа илүү огцом гүнзгий байх ба дээд тал нь эрэг үүсгэсэн байх нь элбэг. Тэгвэл гангагуу хоёр нь хоёр уулын хооронд бус нэгэн уул, өндөрлөгийн суга, бэл, хормойд тохиолдох ба хоорондоо бас ялгаатай. Тухайлбал хад чулуу, хайрга шорооноос тогтсон эгц өндөр,огцом эргийг ганга гэдэг бол,гуу гэдэг нь хэвгий уруу газрын хөрс цас борооны усанд идэгдсэнээс үүссэнбяцхан элс шороон суваг юм.**

ХӨНДИЙ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд:**“Хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар” уулын хөндий /уул нуруудын хоорондуур үргэлжилсэн тэгш тавиу газар/, тал хөндий хоршоо /уул хоорондын өргөн уудам зай болон тэгш нам дор газар/, хөндий цайдам хоршоо /хоёр уулын хооронд орших өвс ногоо жигдэрсэн болон өвс ногоо халцгайвтар тэгш тавиу уудам газар/, 2. Хоёр голын хоорондох тэгш тавиу газар; голын хөндий /хоёр голын хоорондох үргэлжилсэн тэгш тавиу газар/, **Товч тайлбар тольд:**“2. Хоёр хэсэг уул нуруу мэтийн хоорондуур үргэлжлэн алсалсан тэгш тавиу газар, 3. Хоёр голын хоорондох тэгш тавиу газар” хэмээн тайлбарласан байна.**Монгол хэлний тольд:** “хоёр уул буюу хоёр өндөрлөг газрын хоорондох ихээхэн тэгш нам газар; хөндий тал /1. Нам дор тал газар, 2. Айл амьтангүй цэлгэр зэлүүд тал газар, голын хөндий, уулын хөндий” хэмээн тайлбарласан бол**Монгол-орос их тольд:**“2.2. долина;ущеле, голын хөндий речная долина, падь, ущелье;” гэжээ.

ХООЛОЙ гэдэг үгийг **Дэлгэрэнгүй тайлбар тольд:**“3. Хоёр уулын хоорондох өргөн тавиу газар”, **Товч тайлбар тольд:** “3. Хоёр уулын хоорондох өргөн хөндий, 4. Хоёр нуурыг холбосон горхи суваг ”**Монгол хэлний тольд** “4. Хоёр уулын хоорондох өргөн хөндий” гэж тус тус тайлбарласан байна. Тэгвэл **Монгол-орос их тольд:**

“широкая долина между двух горных хребтов, ущелье; самое низкое место долины/по которому стекают дождевые воды/” гэжээ. Өөрөөр хэлбэл монгол хэлний дурдсан тайлбар толиудад хөндий, хоолой хэмээх хоёр үгийг утгын ялгаагүйгээр бараг ижилхэн тайлбарласан төдийгүй, Товч тайлбар толь, Монгол хэлний толь хоёр хоолой гэдэг үгийг “өргөн хөндий” гэж нөгөө үгээр нь тайлбарласан байх юм. Монголын их зохиолч Д.Нацагдорж “Миний нутаг” шүлэгтээ: **“Хүлэг морьд уралдсан хөндий сайханхоолойнууд”** гэж шүлэглэсэн байдгаас үзвэл энэ хоёр үгийн утга үнэхээр ойрхон нь илэрхий мэдэгдэж байна. Гэвч ямар ч ялгаагүй, яг ижил утгатай хоёр үг аль ч хэлэнд байдаггүй. **Бидний бодлоор, “Хоёр уулын хоорондох өргөн тавиу газар” гэдэг тайлбар хоолой гэсэн үгэнд нь илүү тохирно. Харин хөндий гэдэг нь заавал хоёр уулын хооронд байх албагүй, харин гол мөрний хоёр талыг даган үргэлжлэх тэгш тавиу, нам газар билээ. Товч тайлбар толь болон Дэлгэрэнгүй тайлбар тольд дурдсан шиг заавал хоёр голын хооронд байх нь хөндийн үндсэн шинж биш бөгөөд бид Орхоны хөндий, Хэрлэнгийн хөндий, Туулын хөндий гэж ярьж бичдэг шүү дээ.**

Өнөөгийн монгол хэлэнд уугуул үндсэн утга нь бүдгэрэн балархайшиж, ихэвчлэн хоршоо үгийн бүрэлдэхүүнд орж хэрэглэгдэх болсон хэдэн зуун үг байгаагийн заримаас нь товч өгүүллээ. Цаашид эдгээр үгийн үндсэн утгыг нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд “Монгол үгийн утга салгасан толь” ч хийж болох байна. Эцэст нь дүгнэлт болгон хэлэхэд Нэгдүгээрт, Монгол хэлний тайлбар тольд үгсийн утгыг тайлбарлахдаа өмнөх толь бичгүүдийн тайлбарыг хянан нягталж, нэмэн засаж боловсруулахгүйгээр шууд хуулан авах, эсвэл тухайн зохиогч судалгаа хийлгүйгээр өөрийн мэдлэгийн хэмжээнд шууд тайлбар бичих дутагдал ажиглагдсаар байна. Энэхүү дутагдлыг даруй засаж, тухайн үгийнхээ үндсэн болон салаа утгуудыг утгын орон /семантическое поле/-д нь хоршоо үг, холбоо үгийн төвшинд нарийвчлан судалсны үндсэн дээр тайлбар өгөх хэрэгтэй. Хоёрдугаарт, Хоорондоо ихээхэн ойролцоо утга илэрхийдэг ч гэсэн үг тус бүрийн бие биеэсээ ялгарах үндсэн утгын нарийн зааг, ялгааг гаргахгүйгээр нэг үгийг нөгөөгөөр нь зөрүүлэн тайлбарлаж болохгүй. Ийм нөхцөлд хоёр үг хоёулаа тайлбаргүй болно. Ялангуяа ойролцоо утгатай хоёр үгээс бүтсэн хоршоо үгийн бүрэлдэхүүнд ордог үгсийн тайлбарт онцгой анхаарах ёстой. Гуравдугаарт, Хоршоо үг үүсгэж байгаа хоёр үгийн нэгийг тайлбарлаад нөгөөг нь тусгайлан тайлбарлалгүй, тайлбар хийсэн өмнөх үгээ зааж бас болохгүй. Хэрэв тэгвэл тэр хоёр үг яг ижил утгатай гэсэнтэй адил бөгөөд тэд дундаа ганц тайлбартай үлдэх болно. Дөрөвдүгээрт, Толийн толгой үгийн дотор жишээ болгон авсан хоршоо үгийг тухайн үгтэй утгын холбоо бүхий ойролцоо утгатай хоршоо үгээр нь зөрүүлэн тайлбарлаж бас болохгүй. Тайлбар толийн үгийн тайлбар ерөнхий, нуршуу биш, ойлгомжтой, товч байх ёстой. Манай тайлбар толиудын зарим үгийн тайлбар оновчтой бус, хэтэрхий ерөнхий, ойлгомжгүй байгааг /өмнө дурдсан зарим үгийн тайлбарт бас хамаарна/ анхаарч тухайн үг бусад үгээс, ялангуяа ойролцоо утгатай бусад үгээсээ юугаараа ялгаатайг онож тайлбарлах ёстой. Тавдугаарт, Хүний нийгмийн бүхий л харилцаа хэлээр дамжин хэрэгждэг учраас дээр дурдсан шиг тодорхой бус утгатай үгс нийгмийн харилцаанд бэрхшээл учруулахыг үгүйсгэх аргагүй юм. Ялангуяа төр, засгийн аливаа хууль, дүрэм журам, төв орон нутгийн удирдах байгууллагуудын захирамж, тогтоол шийдвэрээс эхлэн байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн хооронд хийх аливаа эрх зүйн гэрээ, хэлцэл, бичиг баримтуудад ийм тодорхой бус, хэн нэгэн хүн, хуулийн этгээд өөрт ашигтайгаар мушгин тайлбарлаж болох үг, нэр томъёог

оруулбал гарах үр дагавар нь тодорхой. Үгийн сангийн суурь судалгаа болсон тайлбар тольд ч үгийн утга хэн ч маргахааргүй тодорхой байх ёстой

Аливаа хэлний дэлгэрэнгүй их тайлбар толь нь хоёр болон олон хэлний орчуулгын толь, сургалтын толиуд, идэвхитэй үгийн толь, үгийн язгуурын толь, өвөрмөц хэллэгийн толь, ойролцоо үгийн толь гэх мэтийн хэл шинжлэлийн олон зүйл толь бичгүүдийн үндэс болдгоороо үгийн сангийн суурь судалгааны бүтээл болдог. Нэг үгээр хэлбэл, сайн тайлбар тольгүйгээр дээрх олон төрлийн толиудыг зохиох боломж хомс юм. Бас тайлбар толь нь өөрөө өмнө гарсан бүх тайлбар толь бичгүүдийг ашиглан тэднийг толгой үгийн хувьд төдийгүй тайлбарын хувьд ч улам баяжуулан сайжруулж байдаг ба өмнөх толь бичгүүдийг ашиглахгүй цоо шинээр тайлбар толь зохиох боломж ч үгүй билээ. Иймээс тайлбар толь нь тухайн ард түмний ахуй амьдрал, түүх, соёлын хөгжлийн багагүй хугацааг хамарсан олон хүний хамтын хүч хөдөлмөрийн үр дүнд бий болдог ихээхэн үнэ цэнэтэй бүтээл юм. Энэ өнцгөөс харах юм бол, үе үеийн тайлбар толиос тухайн үгийн утгын хувирал, өөрчлөлтийг бага ч гэсэн харах боломж олдоно хэмээн үзэж байна. Тийм болохоор энэхүү өгүүлэлд харьцуулан үзэж байгаа үгсийн тайлбарын зөрүүнүүдийг тухайн толийн зохиогчийн алдаа, буруу хэмээн яаран дүгнэхгүй байхыг хүсч байна. Магадгүй, тухайн үгийн утга олон арван жилийн өмнө өнөөгийн бидний ойлгодогдоос арай өөр ч байсан байж болох шүү дээ. “Монгол улсын шинжлэх ухаан” 108 боть цуврал бүтээлийн 12 дугаар боть болон хэвлэсэн “Монгол хэлний үгийн сан судлал” номын 126-р талд Оросын эрдэмтэн А.И.Соболевскийн “Чухамдаа толь зохиох гэдэг нь ёстой хүчир бөгөөд үнэлэгддэггүй ажил тул түүний алдаа мадагт нь ч гэсэн хамгийн ээвэргүү хандвал зохино”/7:126/ гэсэн маш үнэн үгийг энд давтан хэлэх нь зүйтэй.

НОМЗҮЙ

1. Сэржээ Ж. Монгол хэлний төрөл садан, удам угсааг заадаг зарим үгийн утгын тухай. МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал” эрдэм шинжилгээний бичиг 2012 он, Боть XXXIY (360) 68-75-р тал
2. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Таван боть, Ерөнхий редактор Л.Болд, УБ. 2008 он
3. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он
4. Монгол хэлний толь. Эрхлэн найруулагч Ц.Норжин, Ман.Мөрөн. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он
5. Монгол-орос дэлгэрэнгүй их толь. Дөрвөн боть, Хариуцлагатай редактор Г.Ц.Пюрбеев, М. “ACADEMIA” 2001 он.
6. Монгол үгний тайлбар толь. Шагж найруулан зохиов. Бээжин, 1998 он.
7. Монгол хэлний үгийнсан судлал “Монгол улсын шинжлэх ухаан” цувралын 12 дугаар боть УБ. 2009 он. 126-р тал

SUMMARY

Synonymic meaning or each basic meaning of a word in the structure of compound word becomes blurred broadly in the modern Mongolian language. For example, words such as **садан төрөл, төрөл садан** (relative) frequently occur, but what is the exact meaning of **төрөл**? What is the exact meaning of **садан**? What are the differences between these two words? The meanings of these have been explained incorrectly or in different meanings in varying dictionaries.

In this article, the author analyzed this phenomenon among many words in modern Mongolian and examines words related to the earth and various surfaces such as Хөвч, Тайга, Зүлэг, Ширэг, Булаг, Шанд, Жалга, Судаг, Гуу, Ганга, Хөндий, Хоолой, Царам, Сарьдаг.